



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 09 өдөр

Дугаар А/З

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.1, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2018 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулагдах Ардчилсан үндсэн хууль батлагдсан өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд оролцох төлөөлөгчдийн зардалд зориулж 2746000 /хоёр сая долоон зуун дөчин зургаан мянган/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн болзошгүй зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

Аймгийн Засаг даргын 2018 оны
0... дугаар сарын... өдрийн А/З
дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

Зардлын нэр	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Бүгд үнэ
Шатахуун	800 км/ 2 машин	320 л/ 1800 төг	576 000
Хоол			
2018.01.13-ны өдрийн үдийн зоог	46000	15 хүн	690 000
2018.01.13-ны өдрийн өглөөний зоог	10000	13 хүн	130 000
Буудлын төлбөр	30000	13 хүн	390 000
Бэлэг дурсгал	80 000	12 хүн	960 000
Нийт үнэ			2,746,000